



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 08 сарын 24 өдөр

Дугаар 245

Улаанбаатар хот

Г Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх г
тусгай зөвшөөрлийн тухай журмын 2.1.3 дахь заалтыг
өөрчлөн найруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“2.1.3. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 19.2.11 дэх заалтад заасны дагуу брокер, дилер, андеррайтерийн компани нь хувь нийлүүлсэн хөрөнгийн 3 хувиас доошгүй хувьтай тэнцэх хэмжээгээр эрсдлээс хамгаалах сан байгуулж, сангийн хөрөнгийг “ҮЦТТТХТ” ХХК-ийн тусгайлсан дансанд, “ҮЦТТТХТ” ХХК-нь тус сангийн хөрөнгийг зэрэглэл өндөртэй арилжааны банкинд тус тус давхар байршуулах”

2. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан холбогдох журамд өөрчлөлт оруулсантай холбогдуулан бүх зохицуулалтын хүрээний байгууллагуудын эрсдлийн сангийн мөнгөн хөрөнгийг 2011 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор “ҮЦТТТХТ” ХХК дээр байршуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Үнэт цаасны газар /С.Тулгаа/-т, эрсдлийн сангийн хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус даалгасугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /С.Тулгаа/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газарт тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН